13	Мандал даатгал	415	24,301,972	1,794	217,594,447	379	9,483,787	0	0	2,588	251,380,206
14	Хаан даатгал	1,232	48,393,652	1,102	114,139,828	88	2,288,385	0	0	2,422	164,821,865
15	Агула даатгал	525	40,399,844	412	45,891,225	13	394,350	0	0	950	86,685,419
	<b>Нийт</b>	<b>41,694</b>	<b>1,906,257,790</b>	<b>19,304</b>	<b>1,968,705,211</b>	<b>1569</b>	<b>40,067,357</b>	<b>603</b>	<b>82,935,552</b>	<b>63,170</b>	<b>3,997,965,910</b>

*/Хүснэгт №1-ийн гэрээний тоо, хураамжийн орлогоос цуцлагдсан гэрээний тоо дүн ороогүй учир зөрүүтэй болно./*

## 6.2 Жолоочийн даатгалын нөхөн төлбөр

Албан журмын даатгагчдын холбооны гишүүн 10 даатгалын компани болон Холбооны даатгалын сангаас 2023 оны 10-р сард нийт **826** даатгалын тохиолдолд **833,082,715** төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байна.

Хохирлыг эрсдлийн ангилал тус бүрийн хувьд авч үзвэл тээврийн хэрэгсэлд хохирол учруулсан **814** даатгалын тохиолдолд **816 сая** төгрөгийн нөхөн төлбөр, бусад хөрөнгөд хохирол учруулсан **10** даатгалын тохиолдолд **12,5 сая** төгрөгийн нөхөн төлбөр, эрүүл мэндэд хохирол учруулсан **2** даатгалын тохиолдолд **4,7 сая** төгрөгийн нөхөн төлбөр тус тус олгосон байна.

Даатгалын компани тус бүрийн хохирогчид олгосон нөхөн төлбөрийн тоо, нөхөн төлбөрийн хэмжээг хүснэгт №4-өөс харна уу.

## **Хүснэгт №4. Нөхөн төлбөр /даатгалын компани тус бүрээр/**

д/д	Нэрс	Тээврийн хэрэгсэл		Бусад хөрөнгө		Амь нас		Эрүүл мэнд		Нийт	
		Т/тоо	Нөхөн төлбөрийн дүн	Т/тоо	Нөхөн төлбөрийн дүн	Т/тоо	Нөхөн төлбөрийн дүн	Т/тоо	Нөхөн төлбөрийн дүн	Т/тоо	Нөхөн төлбөрийн дүн
1	Миг даатгал	0	0	0	0	0	0	0	0	0	0
2	Мөнх даатгал	66	67,869,606	1	1,232,421	0	0	0	0	67	69,102,027
3	Монгол даатгал	0	0	0	0	0	0	0	0	0	0
4	Практикал даатгал	279	287,737,513	5	6,945,600	0	0	2	4,744,205	286	299,427,318
5	Амар даатгал	0	0	0	0	0	0	0	0	0	0
6	Улаанбаатар хотын даатгал	0	0	0	0	0	0	0	0	0	0
7	Номин даатгал	277	261,764,870	0	0	0	0	0	0	277	261,764,870
8	Тэнгэр даатгал	70	82,498,458	3	3,630,721	0	0	0	0	73	86,129,179
9	Бодь даатгал	0	0	0	0	0	0	0	0	0	0
10	Ган зам даатгал	2	8,646,000	0	0	0	0	0	0	2	8,646,000
11	Монре даатгал	0	0	0	0	0	0	0	0	0	0
12	Ард даатгал	39	37,259,533	0	0	0	0	0	0	39	37,259,533
13	Мандал даатгал	74	48,968,888	1	700,000	0	0	0	0	75	49,668,888
14	Хаан даатгал	0	0	0	0	0	0	0	0	0	0

15	Агула даатгал	2	2,100,000	0	0	0	0	0	2	2,100,000	
16	АЖДХ	5	18,984,900	0	0	0	0	0	5	18,984,900	
<b>Нийт</b>		<b>814</b>	<b>815,829,768</b>	<b>10</b>	<b>12,508,742</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>4,744,205</b>	<b>826</b>	<b>833,082,715</b>

### Хүснэгт №5. Нөхөн төлбөрийн тоо, нөхөн төлбөрийн хэмжээ /төгрөг/

№	Хэмжээний интервал	Даатгалын тохиолдлын тоо	Нөхөн төлбөрийн нийт дүн
1	200,000 хүртэл	56	9,007,127
2	200,000-с 500,000	305	99,907,256
3	500,000-с 800,000	163	102,542,938
4	800,000-с 1,000,000	66	58,166,217
5	1,000,000-с 1,499,999	87	105,171,776
6	1,500,000-с 1,999,999	47	82,443,143
7	2,000,000-с 2,999,999	38	93,815,065
8	3,000,000-с 3,999,999	26	90,921,869
9	4,000,000-с 4,999,999	13	56,807,400
10	5,000,000-с 7,999,999	24	125,859,924
11	8,000,000-с 9,999,999	1	8,440,000
12	10,000,000-с	0	0
<b>Нийт</b>		<b>826</b>	<b>833,082,715</b>

### 6.3 Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдалт

#### Хүснэгт №6. Жолоочийн даатгалд хамрагдалт

д/д	Үзүүлэлт	2023.10.01-2023.10.31
1	Даатгалын гэрээний тоо	62,026
2	Даатгалын хураамж /төг/	3,916,695,992
3	Нөхөн төлбөр авсан тоо	826
4	Олгосон нөхөн төлбөр /төг/	833,082,715
5	Дундаж хураамжийн дүн/төг/	63,146
6	Дундаж нөхөн төлбөрийн дүн /төг/	1,008,575

### 6.4 Даатгалын зуучлагч компани

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компаниас 2023 оны 10-р сард зуучлагч 29 компани **24,732** даатгалын гэрээ байгуулж, **1,46 тэрбум** төгрөгийн даатгалын хураамжийн орлого бүрдүүлсэн байна. 2023 оны 10-р сард нийт гэрээний тоонд эзлэх хувь **39,9%**, нийт хураамжийн дүнд эзлэх хувь **37,3%** байна.

#### Хүснэгт №7. Жолоочийн даатгалын гэрээ /Зууч компаниар/

№	Даатгалын зууч компани	Даатгалын гэрээ	
		Гэрээний тоо	Хураамжийн дүн
1	Профешнл иншурэнс партнер	1,013	60,267,476
2	Сүрэг хараацай	3,062	185,339,582
3	Смарт брокерс	1249	71,123,198
4	ХААН Банк	51	1,762,858
5	Лоялти Солюшн	465	24,949,958
6	Эрсдэлийн шийдэл	2106	129,902,666
7	Ачит-Ундарга	129	6,870,446
8	Төрийн банк	883	32,654,171
9	Дархан шаркс ХХК	1733	114,351,970
10	Монгол бичээч	125	9,339,765
11	Дэвжих дэлгэрэх	207	13,351,661
12	ХАС банк	17	873,169
13	МАСТЕР ШИЙДЭЛ	135	6,644,583
14	ХХБ	115	7,068,423
15	LBVbrokerage ХХК	10	617,508
16	Си Эн Эн Икс	2227	126,252,970
17	Цагаан гэрэлт	475	27,445,173
18	Тод Капитал	1177	63,830,173
19	Нэйшнл Эженси	710	85,146,705
20	МІВ	45	3,494,925
21	Эм Жи Ай Би ХХК	722	43,606,596
22	Амарди дижитал ХХК	882	55,781,733
23	Дэвжих зууч ХХК	1658	97,763,505
24	Ваясьню Солюшин ХХК	5	322,656
25	Асимон	2,448	112,623,868
26	Цахим капитал ХХК	1,496	83,517,484
27	ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНК	5	274,635
28	НЭЙШНЛ ИНШУРАНС БРОКЕРЭЙЖ СЕРВИСЕС	5	320,562
29	Онч цэгц ХХК	1,577	93,830,306
<b>Нийт дүн</b>		<b>24,732</b>	<b>1,459,328,725</b>

### ЖОЛООЧИЙН ДААТГАЛД ХАМРАГДСАН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН СУДАЛГАА

2023 оны 10-р сард “В” ангиллын тээврийн хэрэгслийн гэрээ хамгийн их буюу **52,298** байгуулагдаж, **3,87 тэрбум** төгрөгийн хураамжийн орлого бүрдүүлсэн байна.

**Хүснэгт №8.** Тээврийн хэрэгслийн ангиллаар

№	Зүйл /Ангилал/	Даатгалын гэрээний тоо	Даатгалын хураамжийн дүн
1	А	234	5,386,858
2	В	52,298	2,864,274,352
3	С	6,553	896,156,408
4	Д	730	89,368,577
5	М	677	22,148,525
6	Бусад	2	213,460
	<b>Нийт</b>	<b>60,494</b>	<b>3,877,548,180</b>

*/\* Мэргэшсэн жолоочийн даатгалын гэрээний тоо, хураамжийн дүн ороогүй болно./*

## Долоо. Татварын байгууллагын мэдээлэл

Татварын ерөнхий газраас ЗХАБҮЗ-д авто тээврийн хэрэгслийн бүртгэл болон төлөлтийн мэдээлэл / 2023 /

### Татварын ерөнхий газраас ЗХАБҮЗ-д авто тээврийн хэрэгслийн бүртгэл болон төлөлтийн мэдээлэл / 9 сарын 20 - 10 сарын 20 хүртэл /

Аймаг нэр	Татвар Төлөг- чийн Тоо	Тээврийн хэрэгс- лийн тоо	АТБӨЯХАТ ногдол	АТБӨЯХАТ төлөлт	АБТ ногдол	АБТ төлөлт	АЗАТ ногдол	АЗАТ төлөлт
Архангай	77	77	1221198	626846	285000	70800	256979	246979
Багануур	30	35	524023	262223	90400	40600	251332	122065
Багахангай	3	3	27594	16457	3900	2100	23271	7336
Баянгол	725	1344	23844366.3	7231874.9	3388900	933400	23200903	4860755
Баянзүрх	952	1420	21552482.7	7516272.7	3781550	1170950	14054813	4507792.6
Баян-Өлгий	62	66	1222138	1018519	153715	90315	196731	196731
Баянхонгор	65	70	994211.04	575590.04	171150	58550	223532	208532
Булган	59	59	810548.96	458317.96	194800	50500	100000	100000
Говь-Алтай	55	56	782377	545734	172600	46500	185550	180000
Говьсүмбэр	23	23	277835	53471	108900	16100	8242	8242
Дархан-Уул	96	115	1872815.5	1044832.5	347600	162300	327463	297792
Дорноговь	89	95	2717246	2125094	274500	82000	243304	243304
Дорнод	69	79	1662832.9	1327596.9	232100	110800	511022	511022
Дундговь	47	48	730728.2	279057.2	173400	31700	92000	92000
Завхан	40	40	604413	391199	98000	19500	165000	165000
Налайх	53	55	895500	165225	158700	20100	477113	78493
Орхон	152	194	3211008.4	1844897.4	610099	233099	440522	440522
Өвөрхангай	100	116	2479049.5	1354691.5	280600	120000	768170	597920
Өмнөговь	108	177	8917777.21	5424938.8	512426	247426	499189.64	341189.6
Сонгино- хайрхан	568	793	13190373.8	5978805.9	2038683.3	764883.33	6175368.14	2483875.6
Сүхбаатар Сүхбаатар дүүрэг	49	58	1189093.5	532150.5	249000	49400	189171	171171
Сэлэнгэ	815	1359	29404892.7	7252803.41	3843094.3	967394.35	26261573.65	4549264.6
Төв	71	77	965843	510254	301900	83000	193633	193633
Төв	68	68	852565.34	383659.34	350400	52500	156221	126188
Увс	54	57	1036530	580569	227700	72200	174396	174396
Хан-Уул	720	1225	36070048.5	14872486.2	3682300	1397700	21718228	5979278
Ховд	92	101	1571926.66	711013	409500	143000	304364	159614
Хөвсгөл	71	78	1271042.5	537793.5	362000	62300	241292	241292

Хэнтий	66	67	995175	341038	343900	51500	138683	118683
Чингэлтэй	359	750	20771781.4	9882669.4	2153715	660515	10799349.66	3772633.6
<b>Нийт дүн</b>	<b>5738</b>	<b>8705</b>	<b>181667417.6</b>	<b>73846080.6</b>	<b>25000532.6</b>	<b>7811132.68</b>	<b>108377416.1</b>	<b>31175704.2</b>

## **Найм. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа**

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймагт ажилласан тухай

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрэм журмын хэрэгжилтийг аймаг орон нутагт үзэж танилцах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, Өндөрхаан-Норовлин чиглэлийн 130 км хатуу хучилттай авто замын төслийн хэрэгжилт, хөдөлгөөний зохицуулалт, нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэмжээний санал зөвлөмж боловсруулах зорилгоор Зам, тээврийн хөгжлийн яамны Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга Ё.Жаргалсайхан, мэргэжилтэн Б.Батхорол, Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын Орон нутаг, замын хяналтын хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Бүрэнтөгс нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2023.10.16-20-нд Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудад ажиллаж, дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хэнтий аймагт хэрэгжиж Өндөрхаан-Норовлин чиглэлийн 130 км хатуу хучилттай авто замын төслийн авто зам, замын байгууламжийн барилгын ажлуудтай танилцаж, Батноров сумын төвөөр дайран өнгөрөх хэсгийн уулзвар, гарц, авто зогсоолыг шинээр төлөвлөх, тэмдэг тэмдэглэгээ байрлуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулан ажиллахад дэмжлэг үзүүлэв. Уг ажлын хүрээнд Хэнтий аймгийн Батноров сумын ИТХ-ын дарга О.Аюуш, Засаг даргын орлогч Б.Ган-Эрдэнэ, Тамгын газрын дарга А.Борчулуун, Санхүүгийн албаны дарга Л.Авирмэд, Сургуулийн захирал Г.Цэцэгсүрэн, Соёлын төвийн эрхлэгч П.Саранзаяа болон төслийн гүйцэтгэгч Наранбулагхан ХХК-ийн ерөнхий инженер Пүрэвжаргал, замын инженер Б.Баяр-Эрдэнэ, Хэнтий аймгийн Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч Г.Баяржаргал нартай уулзаж, сумын төвийн дундуур шинээр баригдсан улсын чанартай автозамаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөн эрчимжиж байгаатай холбогдон үүсч байгаа эрсдэл, асуудлууд, түүнийг шийдвэрлэх арга зам, саналуудыг хэлэлцэж, шийдэлд хүрч, талуудын оролцож шийдвэрлэсэн хурлын тэмдэглэл гаргасан. Үүнд:

- Сумын сургууль болон суурьшлын 70% нь автозамын урд талд байдаг, хойд талаас хүүхдийн автозам хөндлөн гарах хөдөлгөөн нилээд байгаа тул явган хүний гарцыг уулзвараас зайтай гаргах, үүнтэй холбоотойгоор замын дагуу мод тарьсан хашаан дундуур явган хүний гарц гаргах, хурд сааруулагчийг стандартын дагуу хийх, байршлыг оновчтой тогтоох саналыг сумынхан болон төслийн гүйцэтгэгчид зөвлөмж болгосон.

- Сумынхны хүсэлтийн дагуу 3 байршилд уулзвар болон явган гарцыг нэмэлтээр хийхээр болсон.
- Сумын төвийг дайрч өнгөрч буй автозамын гэрэлтүүлэг, үер уснаас хамгаалах арга хэмжээг сумын хөгжлийн төлөвлөлтийн хүрээнд шийдвэрлэхээр болсон.
- Шинээр баригдаж буй автозамаар Батноров, Норовлин, Дорнодын Баян-Уул сумаас Бор-Өндөр чиглэлд жонш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүнийг 70-100 тн-оор даац хэтрүүлэн тээвэрлэж, автозамыг эвдэж гэмтээх нөхцөл бүрдэж байгаа тул тээвэрлэлт гүйцэтгэж буй хүнд даацын автомашины судалгааг гаргах, нийтийн зориулалттай автозамаар тээвэрлэлт гүйцэтгэх стандартын шаардлагыг мөрдүүлэх, үнэхээр зайлшгүй даац хэтрүүлж тээвэрлэлт хийх шаардлагатай бол зориулалтын хүнд даацын автозам барих шаардлагуудыг уурхайнуудад хүргүүлэх зөвлөмжийг өгсөн.

Мөн ажлын хэсгийнхэн Батноров-Норовлин-Баян-Уул чиглэлийн автозам барих төслийн гүйцэтгэгч нартай уулзаж, төслийн ажлын явцтай танилцсан.

2. Ажлын хэсэг Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, ИТХ-ын ГХУССЗ-ийн нарийн бичгийн дарга Ц.Одчулуун, ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ц.Баяржаргал, Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга М.Нямсүрэн, Хөрөнгө оруулалтын хэлтсийн автозамын хяналтын улсын байцаагч М.Ганбат, автотээврийн хяналтын улсын байцаагч Г.Эрдэнэбаатар, зөвлөх инженер Сүхбаатар, Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Х.Батсайхан, Дорнод Авто зам ХК-ийн гүйцэтгэх захирал Э.Түвшин, Чойбалсан хөгжил ОНӨААТҮГ-ын дарга З.Гэрэлт-Од, Автотээврийн төвийн автотээврийн хяналтын улсын байцаагч Э.Батхүү нартай уулзаж, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйл дэх аймгийн ИТХ, Засаг даргын бүрэн эрх, үүрэгт хамаарах 16 заалт бүрийн хэрэгжилтийн талаар газар дээр нь үзэж танилцсан нөхцөл байдлын дагуу дэлгэрэнгүй ярьж, аймгийн удирдлагаас зарим ажлуудыг газар дээр нь шийдвэрлэсэн бөгөөд мөн ажлын хэсгээс тодорхой зөвлөмж чиглэлийг өгсөн. Үүнд:

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9.1.2-т заасан олон нийтийн цагдаа ажиллуулах талаар замын цагдааг хэв журмын цагдаагаас тусад нь ЗЦТ-ийн мэдэлд шийдэх, цалин 450,0 мянган төгрөг байгааг 1,0 сая төгрөг болгох, гүйцэтгэх ажил үүрэг, хариуцлагыг тодорхой болгох;
- Замын цагдаагийн 17 албан хаагчдын бэлэн бус торгуулийн төлбөрийн төхөөрөмжийн ажиллагааг хангах;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний санхүүжилт 10,0 сая төгрөг байгааг тодорхой төсөл арга хэмжээнд чиглүүлж дорвитой нэмэгдүүлэх;
- Хуулийн 9.2.2-т тусгагдсан зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх дунд болон богино хугацааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх
- Чойбалсан хот доторх нийтийн тээврийн үйлчилгээний 7 чиглэл /зөвхөн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үнэ төлбөргүй үйлчилдэг/-ийн зогсоолын тохижилт, тэмдэг, тэмдэглэлийг сайжруулах, шаардлага хангахгүй болж зогссон бага оворын 2 автобусны оронд шаардлага хангах тээврийн хэрэгслийг сонгож тээврийн үйлчилгээг тасалдуулахгүй явуулах;



- Таксийн үйлчилгээг цэгцэлж, тээврийн хэрэгслийг бүртгэлжүүлж, стандартын шаардлага хангуулах, тусгай зөвшөөрөлтэй болгох бэлтгэлийг хангах
- Автозамын цэвэрлэгээг сайжруулах;
- Чойбалсан хотын автозамын засвар арчлалтын ажлыг хариуцах мэргэжлийн байгууллагагүй тул засвар арчлалтын ажлын хэрэгцээ шаардлалыг тодорхойлж хөрөнгийг дараа жилийн төсөвт суулган, гүйцэтгэгчийг шалгаруулах гэсээр байтал замын эвдрэл гэмтэл нь улам нэмэгдэж, төсөв нь хүрэхээргүй болдог тул автозамын эвдрэл гэмтлийг тухай бүр засч сэргээж ашиглалтын байнгын бэлэн байдлыг хангах мэргэжлийн байгууллагатай болох;
- Автозамын уулзварын гэрлэн дохио, гудамжны гэрэлтүүлэгийг бүрэн ажиллагаанд оруулах, гэрэлтүүлэг шөнийн 1:00 цаг хүртэл ажиллаад унтардагийг уртасгах;
- Чойбалсан хотын автозамын хурд сааруулагчуудыг 2024 онд бүрэн шинэчлэх;
- Автозамын тэмдэг, тэмдэглэлийг стандарт, дүрэмд бүрэн нийцүүлэх арга хэмжээг мэргэжлийн байгууллага, хүмүүсийн оролцоотой шийдвэрлэх;
- Шинээр худалдан авсан явуулын пүүг автозамын засвар арчлалт хариуцсан байгууллагад хариуцуулан, замын цагдаа, автотээврийн хяналтын улсын байцаагч нар хамтран даац хэтрүүлэх зөрчлийг илрүүлэх, таслан зогсоход чиглүүлж ажиллуулах;
- Улсын чанартай автозам дээр хурд хэтрүүлэх зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дундаж хурдны камер 2-ыг худалдаж авах асуудлыг шийдвэрлэх;
- Чойбалсан хотод Улсын төсвийн 5,5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр шинээр барьсан автозамыг хүлээж авахгүй байсаар засвар арчлалт хариуцах эзэнгүй болж, эвдрэлд орох болсон тул шийдэл гаргаж хариуцах эзэнтэй болгох асуудлыг ЗТХЯ-нд тавих;
- Хүнд даацын автомашины нэгдсэн зогсоолыг хотын баруун /танктай хөшөөний орчимд/, зүүн талд байгуулж, түгээлтийг хот руу жижиг, дунд даацын автомашинаар гүйцэтгэх, нэгдсэн терминал, логистикийн төв байгуулахаар төлөвлөлтийг хийхээр болсон.

3. Сүхбаатар аймагт Засаг дарга М.Идэрбат, ЗДТГ-ын Хуулийн хэлтсийн автозамын хяналтын улсын байцаагч Б.Баатарцогт, Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Б.Баатаржав, Замын цагдаагийн тасгийн ахлах зохицуулагч, цагдаагийн ахлах дэслэгч Д.Батчулуун, Автотээврийн төвийн захирал Э.Ниндэв, автотээврийн хяналтын улсын байцаагч Ө.Төгсжаргал, Талын зам АЗЗА-гийн гүйцэтгэх захирал Б.Түвшинмөнх, Баруун-Урт сумын ЗДТГ-ын мэргэжилтэн О.Энхбаатар нартай уулзав. Баруун-Урт хотын автозамын сүлжээг өртгөтгөх ажлыг сүүлийн жилүүдэд эрчимтэй хийж, 5 тойрог 60 гаруй км автозамтай болж, хотын гаднах хүрээг туузан хашлага бүхий тойрог замтай болгосон байна. Ажлын хэсэг тус хотын замын хөдөлгөөний зохион байгуулалт, гэрэлтүүлэг, гэрлэн дохио, камержуулалт, засвар арчлалт, нийтийн тээврийн үйлчилгээний байдалтай танилцаад, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хийж болох ажлын талаар санал зөвлөмжийг өгсөн. Үүнд:

- Хуулийн 9.2.2, 9.4.1-д тусгагдсан зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх дунд болон богино хугацааны төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж батлуулан хэрэгжүүлэх;
- олон нийтийн цагдааг сонгож ажиллуулах, цалинг 1,0 сая төгрөгөөс багагүй байхаар хөрөнгийг шийдэх, гүйцэтгэх ажил үүрэг, хариуцлагыг тодорхой болгох,
- Баруун-Урт хотын автозам, уулзваруудын камерууд, удирдлагын төв, серверийг сүүлийн үеийн техникээр шинэчлэх ажлыг зохион байгуулах, хотоос гарах 7 гарцыг өндөр хүчин чадлын камераар тоноглож хяналтыг сайжруулах;
- Баруун-Урт хот дотор нийтийн тээвэр, таксийн үйлчилгээг өргөжүүлж зохион байгуулах боломжийг судалж хэрэгжүүлэх;
- Автозамын цэвэрлэгээг сайжруулах;
- Баруун-Урт хотын автозамын засвар арчлалтын ажлыг хариуцах мэргэжлийн байгууллагатай болох боломжийг судлах, ЗТХЯ-наас нэгдсэн шийдэл, чиглэл гаргуулах;
- Автозамын уулзварын гэрлэн дохио, гудамжны гэрэлтүүлэгийг бүрэн ажиллагаанд оруулах, гэрэлтүүлэг шөнийн 1:00 цаг хүртэл ажиллаад унтардагийг уртасгах,
- Автозамын тэмдэг, тэмдэглэлийг стандарт, дүрэмд бүрэн нийцүүлэх арга хэмжээг мэргэжлийн байгууллага, хүмүүсийн оролцоотой шийдвэрлэх;
- Явуулын пүүг шинээр худалдан авах хөрөнгийг шийдвэрлэх, автозамын засвар арчлалт хариуцсан байгууллагад хариуцуулан, замын цагдаа, автотээврийн хяналтын улсын байцаагч нар хамтран даац хэтрүүлэх зөрчлийг илрүүлэх, таслан зогсооход чиглүүлж ажиллуулах;
- Улсын чанартай автозам дээр хурд хэтрүүлэх зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дундаж хурдны камер 2-ыг худалдаж авах асуудлыг шийдвэрлэх.

4. Хэнтий аймгийн Засаг дарга Ц.Чогсомжав, Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч Д.Баяржаргал, Автотээврийн төвийн захирал Ц.Бат-Эрдэнэ, Харгуй ТӨҮГ-ын ерөнхий инженер Г.Төмөрбаатар, Өндөрхаан хотын Хот тохижилтын газрын дарга Б.Дархантөр, Хэрлэн сумын Засаг даргын орлогч Д.Бат-Эрдэнэ, ЗТХТ-ийн ТАЦ-ийн ахлах Э.Амарсайхан нартай уулзаж, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаар холбогдох мэдээллийг авч, Өндөрхаан хотын болон улсын чанартай автозамын нөхцөл байдал, замын хөдөлгөөний зохион байгуулалт, хөдөлгөөний аюулгүй байдал хангагдаж байгаа байдалтай газар дээр нь үзэж танилцав. Мөн бусад аймгуудад Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх талаар хийгдэж буй ололттой ажлууд болон Өндөрхаан-Батноров-Норовлин чиглэлийн шинээр баригдаж буй автозамын төслийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагын талаарх мэдээлэл өгч, зарим асуудлаар санал зөвлөмж өгсөн. Үүнд:

- 3-5 хүртэл олон нийтийн цагдааг томилж ажиллуулах, цалинг 1,0 сая төгрөгөөс бууруулахгүйгээр шийдэх, гүйцэтгэх ажил үүрэг, хариуцлагыг тодорхой болгох;
- Замын цагдаагийн 19 албан хаагчдын бэлэн бус торгуулийн төлбөрийн төхөөрөмжийг шинэчлэх;

- Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх дунд болон богино хугацааны төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах
- Өндөрхаан хотын нийтийн тээврийн үйлчилгээний 5 чиглэл /хүүхэд 200 төгрөг, том хүн 500 төгрөгөөр үйлчлүүлдэг/-ийн зогсоолын тохижилт, тэмдэг, тэмдэглэлийг сайжруулах
- Таксийн үйлчилгээг цэгцэлж, тээврийн хэрэгслийг бүртгэлжүүлж, стандартын шаардлага хангуулах, тусгай зөвшөөрөлтэй болгох бэлтгэлийг хангах;
- Өндөрхаан хотын автозамын засвар арчлалтын ажлыг хариуцах мэргэжлийн байгууллагатай болгох боломжийг судалж, санал боловсруулах;
- Автозамын уулзварын гэрлэн дохио /9-өөс 3 нь ажиллахгүй байгаа/, гудамжны гэрэлтүүлэг /3500 ш байгаа/-ийг бүрэн ажиллагаанд оруулах;
- Автозамын тэмдэг, тэмдэглэлийг стандарт, дүрэмд бүрэн нийцүүлэх, аудит үнэлгээ хийх арга хэмжээг мэргэжлийн байгууллага, хүмүүсийн оролцоотой хийх;
- Шинээр явуулын пүү худалдан авах, замын цагдаа, автотээврийн, автозамын засвар арчлалт хариуцсан байгууллагууд хамтран даац хэтрүүлэх зөрчлийг илрүүлэх, таслан зогсооход хамтарч ажиллах, ялангуяа Норовлин, Батноров чиглэлээс ирж буй хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тавих хяналтыг Бэрх тосгон, Хэрлэнгийн гүүр дээр зохион байгуулах;
- Улсын чанартай автозам дээр хурд хэтрүүлэх зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дундаж хурдны камер 2-ыг худалдаж авах асуудлыг шийдвэрлэх, Дорнод, Сүхбаатар аймаг болон Багануурын хяналтын камеруудтай цогцоор нь хяналт тавих механизмыг бүрдүүлэх;
- Батноров, Норовлин, Дорнодын Баян-Уул сумаас Бор-Өндөр чиглэлд жонш тээвэрлэж буй уурхайнуудад нийтийн зориулалттай автозамаар тээвэрлэлт гүйцэтгэх стандартын шаардлагыг мөрдөх, зайлшгүй даац хэтрүүлж тээвэрлэлт хийх шаардлагатай бол зориулалтын хүнд даацын автозам барих шаардлагуудыг хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль, дүрэм журмын хэрэгжилтийг Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудад үзэж танилцах, мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэг томилолтын ажлын дагуу дараах **санал, дүгнэлт**-ийг танилцуулсан.

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах үүргийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд хариуцуулсан боловч 9 дүгээр зүйлд заасан аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2 эрх /9.1/, 4 үүрэг /9.2/, Засаг даргын 3 эрх /9.3/, 7 үүрэг /9.4/, нийт 16 эрх, үүргийн хэрэгжилтийг зохион байгуулах аймаг дах нэгжийн талаар тодорхой зохицуулалт байхгүй байна. Зарим аймгууд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дор Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах салбар зөвлөлийг байгуулсан байх боловч удирдлага, бүрэлдэхүүн харилцан адилгүй, Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх дунд болон богино хугацааны төлөвлөгөө, хөтөлбөргүй, эсхүл Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөнд хавсаргаж оруулсан, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний санхүүжилт хангалтгүй зэрэг нийтлэг нөхцөл байдал тохиолдож байна. Иймд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлөөс

аймгуудад салбар зөвлөл байгуулах, удирдлага, бүрэлдэхүүн, ажиллах журмын жишиг загварыг боловсруулж хүргүүлэх шаардлагатай байна;

2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9.1.2-т заасан олон нийтийн цагдаа нь орон нутагт замын хөдөлгөөний аюулгүй байдлын хангах хяналт тавихад чухал үүрэгтэй боловч цалин бага тул ажиллах хүн олдохгүй байх, төсөв хөрөнгө хангалтгүй зэрэг хүндрэл байгаа тул олон нийтийн цагдаагийн цалинг 1,0 сая төгрөгөөс багагүй байхаар тооцож, аймгийн болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө, төсөвт тусган шийдвэрлэх, гүйцэтгэх ажил үүрэг, хариуцлагыг тодорхой болгох;

3. Хуулийн 9.2.1-д заасны дагуу замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн шаардлагатай арга хэмжээг орон нутгийн төсвөөс хүрэлцээтэй хамжээгээр санхүүжүүлэх;

4. Хот суурин газрын автозамын тэмдэг, тэмдэглэл, уулзварын гэрлэн дохио, гудамжны гэрэлтүүлэг стандарт, дүрэмд нийцэж буй эсэх, ажиллагааны бүрэн байдалд аудит үнэлгээ хийх ажлын хэсгийг холбогдох мэргэжлийн байгууллага, хүмүүсийн оролцоотой байгуулж ажиллуулах, гаргасан дүгнэлт, санал зөвлөмжийн дагуу замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн шаардлагатай арга хэмжээг авах;

5. Хотын дотор нийтийн тээвэр, таксийн үйлчилгээг цэгцэлж, өргөжүүлж зохион байгуулах, таксийн тээврийн хэрэгслийг бүртгэлжүүлж, стандартын шаардлага хангуулах, тусгай зөвшөөрөлтэй болгох бэлтгэлийг хангах;

6. Хот суурин газрын автозамын засвар арчлалтын ажлыг хариуцах мэргэжлийн байгууллагагүй байгаа, гол төлөв засвар арчлалтын ажлын хэрэгцээ шаардлалыг тодорхойлж хөрөнгийг дараа жилийн төсөвт суулган, гүйцэтгэгчийг шалгаруулах ажиллагааны явцад замын эвдрэл гэмтэл нь улам нэмэгдэж, төсөв нь хүрэхээргүй болдог, иймд автозамын эвдрэл гэмтлийг тухай бүр засч сэргээж ашиглалтын байнгын бэлэн байдлыг хангах мэргэжлийн байгууллагатай болох, энэ ажлыг улсын чанартай автозамын засвар арчлалтыг хариуцдаг АЗЗА компаниар гүйцэтгүүлэх боломжийг судлах, боломжтой бол орон нутагт чиглэл өгөх;

7. Аймаг орон нутагт даац хэтрүүлэх зөрчил түгээмэл гарч байгаа тул зарим аймгуудаас санаачлага гарган шийдвэрлэж байгаа явуулын пүүтэй болох, автозамын засвар арчлалт хариуцсан байгууллагад хариуцуулан, замын цагдаа, автотээврийн хяналтын улсын байцаагч нар хамтран даац хэтрүүлэх зөрчлийг илрүүлэх, таслан зогсооход чиглүүлж ажиллуулах;

8. Улсын чанартай автозамын чанар сайжирч, сүлжээ өргөжихийн хирээр хурд хэтрүүлэх зөрчлийн улмаас ноцтой зам, тээврийн осол зөрчил нэмэгдэж байгаа тул ЗТӨ-оос урьдчилан сэргийлэх зорилгоор дундаж хурдны камертай болох, бусад аймаг, хот суурингуудын хяналтын камеруудтай цогцоор нь хяналт тавих механизмыг бүрдүүлэх.

Эдгээр зөвлөмж саналууд болон Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон хуулийн 9 дүгээр зүйлд заасан аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх, үүргийг хэрэгжүүлэх талаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлөөс 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 12/13 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлөөс 2024 онд эдгээр санал зөвлөмжийн биелэлтийг аймаг орон нутагт үзэж шалгах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж ажиллахаар төлөвлөж байна.



**МОНГОЛ УЛС  
ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ  
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ**

Засгийн газрын 13 дугаар байр, Чингисийн өргөн чөлөө-11,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251  
Утас: (976-51) 26 72 12, Факс: (976-11) 31 23 15  
Цахим хуудас: www.mrtd.gov.mn

2023.11.09 № 12/13  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Санал, зөвлөмж хүргүүлэх тухай**

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлөөс ажлын хэсэг Төв, Дундговь аймагт 2023 оны 09 дүгээр сарын 28-29-ний өдрүүдэд, 10 дугаар сарын 16-20-ны өдрүүдэд Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудад ажиллаж, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Ажлын хэсгийн ажлын тайлан, санал зөвлөмжийн хүрээнд аймгуудад нийтлэг тулгарч байгаа асуудлаар дараах арга хэмжээ авч ажиллахыг чиглэл болгож байна. Үүнд:

1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын эрх, үүргийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгуудад Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зөвлөлийн удирдлага, бүрэлдэхүүн, ажиллах журмын жишиг загварын боловсруулан хүргүүлж байгаа тул аймаг орон нутгийн онцлогийг харгалзан салбар зөвлөлийг байгуулах, Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх дунд болон богино хугацааны төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлж ажиллах;

2.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-т заасан олон нийтийн цагдаагийн цалинг 1,0 сая төгрөгөөс багагүй байхаар тогтоох, орон тоог нэмэгдүүлэх, аймаг орон нутгийн болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөө, төсөвт тусган шийдвэрлэх, гүйцэтгэх ажил үүрэг, хариуцлагыг тодорхой болгох;

3.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн шаардлагатай арга хэмжээг орон нутгийн төсвөөс хүрэлцээтэй хэмжээгээр санхүүжүүлэх;

4.Хот суурин газрын автозамын тэмдэг, тэмдэглэл, уулзварын гэрлэн дохио, гудамжны гэрэлтүүлэг стандарт, дүрэмд нийцэж буй эсэх, ажиллагааны бүрэн байдалд аудит үнэлгээ хийх ажлын хэсгийг холбогдох мэргэжлийн байгууллага, хүмүүсийн оролцоотой байгуулж ажиллуулах, гаргасан дүгнэлт, санал зөвлөмжийн дагуу замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн шаардлагатай арга хэмжээг авах;

03000003

5.Хотын дотор нийтийн тээвэр, таксины үйлчилгээг цэгцэлж, өргөжүүлэх, зогсоол талбайг тохижуулах, тэмдэгжүүлэх, цагийн хуваарьтай болгох, таксины тээврийн хэрэгслийг бүртгэлжүүлж, стандартын шаардлага хангуулах;

6. Аймгийн төвийн автозамын засвар арчлалтын ажлыг хариуцах мэргэжлийн байгууллага байхгүй, энэ ажлын гүйцэтгэгчийг нээлттэй шалгаруулж байгаа боловч өмнөх онд үзэж тодорхойлсон замын эвдрэл гэмтэл нь улам нэмэгдэж, төсөвт суулгасан хөрөнгө нь хүрэхгүй болдог хүндрэл нийтлэг гарч байгаа тул автозамын эвдрэл гэмтлийг тухай бүр засаж сэргээж ашиглалтын байнгын бэлэн байдлыг хангах мэргэжлийн байгууллагатай болох, энэ ажлыг улсын чанартай автозамын засвар арчлалтыг хариуцдаг АЗЗА компаниар гүйцэтгүүлэх боломжтой тул гэрээ байгуулж ажиллах;

7.Аймаг орон нутагт даац хэтрүүлэх зөрчил түгээмэл гарч байгаа тул явуулын пүүтэй болох, автозамын засвар арчлалт хариуцсан байгууллагад хариуцуулан, замын цагдаа, автотээврийн хяналтын улсын байцаагч хамтран даац хэтрүүлэх зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээ авч ажиллуулах;

8.Хатуу хучилттай автозамын урт нэмэгдэхийн хирээр хурд хэтрүүлэхтэй холбоотой зам, тээврийн осол зөрчил эрс нэмэгдэж байгаа тул автомашины хурдыг хянах зорилгоор дундаж хурдны камертай болох, бусад аймаг, хот суурингуудын хяналтын камеруудтай холбож, цогц хяналт тавих механизмыг бүрдүүлэх.

Хавсралт ... хуудастай.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД,  
ҮНДЭСНИЙ ЗӨВДӨЛИЙН ӨРЛӨГЧ  
ДАРГА С.БЯМБАЦОГТ

